


**“ТҮМЭН ШУВУУТ” ХК-ИЙН ЖИЛИЙН САНХҮҮГИЙН БОЛОН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭЛЭЛ**

Хагас жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 2/													
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.													
Тайлагнах хугацаа /Жишээ нь:		2025 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ны өдөр/											
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар		“Түмэн шувуут” ХК, 000188646, MSE:TUM, 70005225											
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр		Монголын хөрөнгийн бирж											
Бизнесийн үйл ажиллагааны салбар		Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэл											
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо		-											
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг		200,000,000											
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр		Бэлтгэсэн: Д.Наранцэцэг Хянасан: Гүйцэтгэх захирал Ж.Болд											
1.	Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/ <table><tr><td>Санхүүгийн байдлын үзүүлэлт</td><td>Тайланг хавсаргав</td></tr><tr><td>Орлогын тайлан</td><td>Тайланг хавсаргав</td></tr><tr><td>Өмчийн өөрчлөлтийн тайлан</td><td>Тайланг хавсаргав</td></tr><tr><td>Мөнгөн гүйлгээний тайлан</td><td>Тайланг хавсаргав</td></tr></table>			Санхүүгийн байдлын үзүүлэлт	Тайланг хавсаргав	Орлогын тайлан	Тайланг хавсаргав	Өмчийн өөрчлөлтийн тайлан	Тайланг хавсаргав	Мөнгөн гүйлгээний тайлан	Тайланг хавсаргав		
Санхүүгийн байдлын үзүүлэлт	Тайланг хавсаргав												
Орлогын тайлан	Тайланг хавсаргав												
Өмчийн өөрчлөлтийн тайлан	Тайланг хавсаргав												
Мөнгөн гүйлгээний тайлан	Тайланг хавсаргав												
1.1.	Хагас жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт Аудит бүтэн жилээр хийгдэхээр 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан тул жилийн тайланд аудитын дүгнэлтийг хавсаргана.												
1.2.	Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/ Аудит бүтэн жилээр хийгдэхээр 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан тул жилийн тайланд аудитын тодорхойлох захидлыг хавсаргана.												
2.	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл												
2.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Санхүүгийн үзүүлэлтүүд Ашигт ажиллагаа											
2.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	<table><tr><td>Нийт хөрөнгийн өгөөж (ROA)</td><td>9,1%</td></tr><tr><td>Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE)</td><td>6,3%</td></tr><tr><td colspan="2">Өөрчлөлтийн хувь /оны эхнээс/</td></tr><tr><td>Нийт активын өөрчлөлт</td><td>30,7%</td></tr><tr><td>Зээлийн багцын өөрчлөлт</td><td>53,4%</td></tr></table>		Нийт хөрөнгийн өгөөж (ROA)	9,1%	Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE)	6,3%	Өөрчлөлтийн хувь /оны эхнээс/		Нийт активын өөрчлөлт	30,7%	Зээлийн багцын өөрчлөлт	53,4%
Нийт хөрөнгийн өгөөж (ROA)	9,1%												
Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE)	6,3%												
Өөрчлөлтийн хувь /оны эхнээс/													
Нийт активын өөрчлөлт	30,7%												
Зээлийн багцын өөрчлөлт	53,4%												


		Хөрөнгөнд эзлэх хувь	
		Өөрийн хөрөнгө /Нийт хөрөнгө	56%
		Өр төлбөр/Нийт хөрөнгө	44%
		Хөрвөх чадварын харьцаа	
		Хөрвөх чадварын хөрөнгө /Татан төвлөрүүлсэн хөрөнгө	1,4%
2.3.	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл	ОХУ-аас худалдан авдаг тэжээлийн түүхий эдийн олдоц муудаж, тэжээл тасалдах хүндрэлээс урьдчилан сэргийлэн БНХАУ-аас болон дотоодын үйлдвэрлэгчдээс зарим түүхий эдийг худалдан авч байна.	
2.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/	Санхүү байдлын тайлангаас гадуурх бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй.	
2.5.	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;	Тайлант хугацаанд: • “Тэжээлийн түүхий эд худалдан авах” зорилгоор Хаан банкнаас 24 сарын хугацаатай, жилийн 15,6%-ийн хүүтэй, 3,000,000.000 /Гурван тэрбум/ төгрөгийн хөрөнгө оруулалтын зээл авсан. Зээлийн барьцаанд 4 үл хөдлөх хөрөнгө, 1 газар /ТУЗ-ийн 2025 оны 02 сарын 15-ний өдрийн хурлаар шийдвэрлэв/ барьцаалсан. • “Тэжээлийн түүхий эд худалдан авах зорилгоор ХХААХҮЯ-ны тахианы аж ахуй эрхлэгчдэд олгох хөнгөлөлттэй зээлийн нөхцөлөөр Голомт банкнаас 24 сарын хугацаатай, жилийн 6%-ийн хүүтэй, 5.000.000.000 /Таван тэрбум/ төгрөгийн эргэлтийн хөрөнгийн зээл авсан. Зээлийн барьцаанд 7 үл хөдлөх хөрөнгө тоног төхөөрөмжийн хамт, 5 газар /ТУЗ-ийн 2025 оны 06 сарын 04-ний өдрийн хурлаар шийдвэрлэв./ барьцаалсан. • Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэн бүтээн байгуулалтын ажил хийх зорилгоор Хас банкнаас 48 сарын хугацаатай, жилийн 8%-ийн хүүтэй, 4,000,000.000 /Дөрвөн тэрбум/ төгрөгийн хөрөнгө оруулалтын зээл авсан. Зээлийн барьцаанд 9 үл хөдлөх хөрөнгө, 2 газар /ТУЗ-ийн 2025 оны 07 сарын 09-ний өдрийн хурлаар шийдвэрлэв/ барьцаалсан. • Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор ХХААХҮЯ-ны тахианы аж ахуй эрхлэгчдэд олгох хөнгөлөлттэй зээлийн нөхцөлөөр Голомт банкнаас 48 сарын хугацаатай, жилийн 6 %-ийн хүүтэй, 4.900.000.000 /Дөрвөн тэрбум есөн зуун сая/ төгрөгийн хөрөнгө оруулалтын зээл авсан. Зээлийн барьцаанд 7 үл хөдлөх хөрөнгө тоног төхөөрөмжийн хамт, 4 газар /ТУЗ-	

		ийн 2025 оны 06 сарын 04-ний өдрийн хурлаар шийдвэрлэв./ барьцаалсан. “Тэжээлийн түүхий эд худалдан авах зорилгоор Голомт банкнаас жилийн 16 хувийн хүүтэй, 7,000.000.000 /Долоон тэрбум/ төгрөгийн аэргэлтийн хөрөнгийн зээл, Зээлийн барьцаанд 7 үл хөдлөх хөрөнгө тоног төхөөрөмжийн хамт, 5 газар /ТУЗ-ийн 2025 оны 12 сарын 29-ний өдрийн хурлаар шийдвэрлэв./ барьцаалсан.
3.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	
	Байхгүй	
4.	Цалин урамшууллын мэдээлэл	
	2025 онд ТУЗ-ийн Хараат болон хараат бус гишүүдэд 37,8 сая төгрөг, Гүйцэтгэх удирдлагад 152,7 сая төгрөгийн цалин олгосон байна.	
5.	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл	
	- ТУЗ нь 2025 оны жилийн хугацаанд нийт 9 удаа хуралдаж, үүнээс цахимаар 1 удаа, Биечлэн оролцсон 3 удаа, эчнээ хэлбэрээр 5 удаа хуралдаж, нийт 23 асуудалд үнэлэлт, дүгнэлт өгч, 9 шийдвэр гаргаж ажиллалаа. Мөн Нэр дэвшүүлэх хороо 1 удаа, Цалин урамшууллын хороо 1 удаа, Аудитын хороо 2 удаа, Ёс зүйн хороо 1 удаа тус тус хуралдаж холбогдох үүргийнхээ хувьд дүгнэлт гаргаж ажилласан байна. - ТУЗ-өөс гаргасан Ногдол ашиг тараахгүй байх тухай шийдвэр болон компани Хувьцаагаа халааслах тухай мэдээллийг 2025 оны 04 сарын 26-ны өдөр зохион байгуулсан “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-д танилцуулан хэлэлцүүлж, батлуулсан. - ТУЗ нь компанийн засаглалын кодексийн зарчмыг хэрэгжүүлэх үүднээс өөрийн үнэлгээг хийж холбогдох байгууллагуудад хүргүүлсэн ба засаглалын кодексийн өөрийн үнэлгээг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Д.Наранццэг гаргаж, нийт 71 оноо буюу 98,6%-ийн үнэлгээтэйгээр холбогдох байгууллага, хүмүүст танилцуулж ажиллалаа. КЗК-ийн хүрээнд тайлант жилд нэмэлтээр хийж гүйцэтгэх ажлуудыг 2025 оны ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэх ажлын төлөвлөгөөнд оруулан хийж гүйцэтгэсэн.	
6.	Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл	
	Байхгүй	
7.	Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/	
	Нийт хувьцаа эзэмшигчийн тоо 2025 оны 04-р сарын 08-ны өдрийн байдлаар 18092 үүнээс 5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигч 4 хүн буюу Л.Эрхэмбаяр 60,000,000 ширхэг хувьцаа-30%, Б.Тунгалаг 60,033,855 ширхэг хувьцаа ба 30,02%, Ж.Болд 20,000,000 ширхэг хувьцаа ба 10%, Э.Баяржаргал-20,000,000 ширхэг хувьцаа ба 10% тус тус эзэмшиж байна.	
8.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл	
	2025 оны эхний хагаст татан төвлөрүүлсэн хөрөнгө байхгүй	
9.	Ногдол ашгийн мэдээлэл	
	2024 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахгүй байх тухай шийдвэрийг 2025 оны 02-р сарын 15-ны өдөр ТУЗ-ийн хурлаас гаргаж, энэ талаар ХЭЭХ-ын үеэр дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн.	
10.	Үнэт цаас гаргагчаас тайлант хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл	

1. “Түмэн шувуут” ХК ажилтнуудынхаа сурч боловсрох, мэдлэг ур чадвараа дээшлүүлэхэд байгууллагын зүгээс анхаарч ажилладаг тул нарийн мэргэжлийн малын эмч, технологичид болон үйлдвэрийн удирдлагуудад зориулан ажлын байранд нь сургалтыг зохион байгуулаа. Уг сургалтыг Малайз улсын Омнисов компанийн зөвлөх багш Daniel Mohan удирдан явуулдаг бөгөөд бид байнга хамтран ажиллаж, сургалт зөвлөгөө өвч ажилладаг.



2. “Түмэн шувуут” ХК-ийн удирдлагууд болон инженер техникийн ажилтнууд Тайланд улсын Бангкок хотод зохион байгуулагдсан шувууны аж ахуйн тоног төхөөрөмж, технологийн олон улсын үзэсгэлэнд оролцож, компанийн тоног төхөөрөмжийн сайжруулалтын судалгаа хийж, холбогдох газруудтай хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллалаа.



3. Швейцарь улсын “BPN” зөвлөх үйлчилгээний байгууллагатай хамтран Байгууллагын гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдэд зориулан удирдах ажилтны арга барилын талаар багц сургалтуудыг авлаа.

4. Компьютерийн Excel программын хэрэглээний Excel, Power BI-н сургалтад оффисын ажилтнуудаа хамрууллаа.



5. Уламжлал болгон зохион байгуулдаг “Шинэ ажилтны аялал” амжилттай боллоо.



Уг ажлын хүрээнд шинээр ажилд орсон ажилтнууд “Түмэн шувуут” ХК-ийн Шувууны аж ахуй-1, Шувууны аж ахуй-2, Шувууны аж ахуй-3, Агро фийд тэжээлийн үйлдвэр болон төв оффистой танилцлаа.



6. “Түмэн шувуут” ХК-ийн нийт ажилчдад зориулан жил бүр зохион байгуулдаг спортын арга хэмжээг 4 төрлөөр амжилттай зохион байгуулж шилдэгүүдээ тодрууллаа.



7. Байгууллагын нийт ажилтнуудын дунд уламжлал болгон зохион байгуулдаг оюун ухааны спорт болох шатрын тэмцээн амжилттай болсон.
8. “Түмэн шувуут” ХКомпани нь 2024 оноос “Түмэн шувуут-3” тахианы аж ахуйн шинэ фермийг барихаар төлөвлөн бүтээн байгуулалтын ажлаа эхлүүлсэн. Тус аж ахуй нь 400,000 өндөглөгч шувууны 8 байр 100,000 дэгдээхэйн 2 байртай юм.




“Түмэн шувуут-3” аж ахуйг шинээр байгуулснаар “Түмэн шувуут” ХКомпанийн өндөглөгч шувууны тоо толгой 1 сая, дэгдээхэйн тоо толгой 300,000-д хүрч, жилд 230-250 сая ширхэг өндөг үйлдвэрлэж, дотоодын өндөгний хэрэглээний 50 хувийг дангаараа хангах боломжтой ба жилд 230-250 сая.ш өндөг үйлдвэрлэж бусад аж ахуйн үйлдвэрлэлийн хамт дотоодын хэрэглээний 90%-ийг хангах нөхцөл бүрдэнэ. Мөн хотын захын дүүрэгт шинээр ажлын байр бий болгож 120 хүнийг байнгын ажлаар хангах юм. Одоогийн байдлаар Дэгдээхэйн 2 байр, Өндөглөгчийн 5 байр бүрэн ашиглалтанл орж үйлдвэрлэл явагдаж байна.



9. Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах ажлын хүрээнд шинээр байгуулж байгаа “Түмэн шувуут-3” шувууны аж ахуйн хамгаалалтын зурвас 780 ш хайлаас мод тарьж, арчилгааг мэргэжлийн цэцэрлүүлэгчид хариуцуулан ажиллаж байна.



10. Олон улсын MNS:ISO9001:2015, MNS:ISO22000:2018 стандартуудыг нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээг ECONATIONAL компанитай хамтран хэрэгжүүлж, нийт 16 дотоод аудиторуудыг бэлтгэлээ.



11. Өндөг түгээлт, борлуулалтын олон улсын шаардлага хангасан Foton Miler 1.5 тн даацтай автомашинуудаар парк шинэчлэлт хийлээ.






12. Компанийн удирдлагын менежментийг сайжруулах зорилгоор Швейцарь улсын шилдэг үйлдвэрлэгч байгууллагуудын үйл ажиллагаатай танилцан туршлага судласан

13. “Түмэн шувуут” ХК-ийн химийн болон микробиологийн лабораториуд нь ISO/IEC 17025 стандартын ээлжит баталгаажуулалтад амжилттай хамрагдлаа.




14. Шувууны эрүүл мэнд, өсөлт, хоол тэжээл, үйлдвэрлэлийн үр ашиг, бүтээгдэхүүний чанарыг тодорхойлох асуудлуудыг хэлэлцэхээр Монгол Улсын 12 аймагт өндөглөгч тахианы аж ахуй эрхэлдэг 20 гаруй аж ахуй нэгжийн 60 гаруй мэргэжилтнүүд, удирдлагууд оролцсон “Feed to Food 2025” форум амжилттай зохион байгуулсан. Тус Форумд зочин илтгэгчдээр АНУ-ын Каргил компанийн Шувууны удам зүй судлаач, Био-генстик инженер Manu De Laet, БНХАУ дахь салбарын малын эмч, мал амьтдын шинжлэх ухааны доктор Yu Yong нар хүрэлцэн ирж мэдлэг мэдээллээ хуваалцсан.





15. Монгол улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх болон Хүнсний хувьсгал ТББ-ын удирдах зөвлөлийн гишүүдэд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар хэрэгжүүлж буй Хүнсний хувьсгал хөтөлбөрийн “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөний хүрээнд олгосон бага хүүтэй, урт хугацаатай хөнгөлөлттэй зээлийн зарцуулалтын тайлангаа танилцууллаа.







16. Компанийн үйл ажиллагаа өргөжиж, үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдэж байгаатай холбогдуулан Агро фийд тэжээлийн үйлдвэрийн байрыг өргөтгөн ашиглалтад орууллаа. Ингэснээр тэжээлийн үйлдвэрлэл тасралтгүй явагдаж, ажлын бүтээмж нэмэгдэж, өдөрт 180-200тн тэжээл үйлдвэрлэх боломжтой болсон.





17. “Түмэн Шувуут” ХК нь Монголын Улаан номд бүртгэгдсэн, говь цөлөөр тархан амьдардаг мазаалайд зориулан тусгай тэжээл үйлдвэрлэж, эхний туршилтыг ZOO Park-ийн “Хүрэн баавгай” дээр амжилттай эхлүүлээ

18. “Түмэн шувуут” ХК нь үржлийн дэгдээхэй бойжуулах шинэ инкубатор төвийг ашиглалтад орууллаа. Шинэ инкубатор төв нь нэг ээлждээ 460 мянган үржлийн өндөг дарж дэгдээхэй гаргах хүчин чадалтай болсон.



Ингэснээр бид өөрийн компанийн болон Монголын бусад өндөглөгч тахианы фермийн дэгдээхэйн хэрэгцээг бүрэн хангах боломжтой болжээ.

19. Өндөгний үйлдвэрлэл нэмэгдэж байгаатай холбогдуулан өндөгний төв агуулахад шинэчлэлт хийж, стандартын шаардлага хангасан 3 давхар агуулах барихаар барилгын ажлыг эхлүүлэн 2026 оны эхний улиралд багтаан ашиглалтад оруулахаар ажиллаж байна.



20. “Түмэн шувуут” ХК-ийн түгээлтийн өргөн сүлжээ, өдөр тутам хэрэглэдэг өндөгний савлагааг ашиглан “Үлгэрийн цаг - 15 минут” аяныг компанийн бүтээгдэхүүнээр дамжуулан нийтэд түгээн, айл бүрийн гэрт цахим номын санг хүргэх ажлыг хамтран зохион байгуулсан.



Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

ЖИГЖИД овогтой БОЛД

“Түмэн шувуут” ХК-ийн гүйцэтгэх захирал

Овог, нэр:

Албан тушаал:

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)

(Тамга/тэмдэг)

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Д.Нарангцэцэг

Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Гарын үсэг: ...*Д. Нарангцэцэг*...